



НҮДНИЙ ХИЙМЭЛ БОЛРЫН ТУХАЙ ӨВЧТӨНД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Хүндэт үйлчлүүлэгч танаа

Та HumanOptics үйлдвэрийн хиймэл болрыг (IOL буюу нүдэн дотор суурилуулдаг линз) хүлээж авлаа. Үйлчлүүлэгчид зориулсан энэхүү гарын авлагад хиймэл болрын талаарх нийтлэг асуултуудын хариултыг тусгасан. Та дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл нүдний эмчдээ хандана уу.

ХИЙМЭЛ БОЛРЫГ ЯМАР ҮЕД ХЭРЭГЛЭХ ВЭ?

Мэс заслаар цайсан төрөлхийн болрыг авч оронд нь хиймэл болор суулгадаг. Ерөнхийдөө энэ аргаар нүдний хараа илт сайжирна.

ХИЙМЭЛ БОЛОР ЯМАР ХҮНД ИЛҮҮ ТОХИРОМЖТОЙ ВЭ?

Нүдний болоргүй болсон насанд хүрсэн хүнд хиймэл болрыг суулгадаг. Төрөлхийн эсвэл гэмтлийн улмаас болоргүй болсон, эсвэл голдуу катарактын мэс заслын үеэр болрыг авсан байж болно. Хүүхэд, жирэмсэн эсхүл хөхүүл эмэгтэйчүүд, дархлааны эмгэгтэй хүнд HumanOptics хиймэл болор суулгах талаар клиник судалгаа хараахан байхгүй.

ХИЙМЭЛ БОЛОР СУУЛГАСНААС ТААГҮЙ НӨЛӨӨ ҮЗҮҮЛЭХ ТОХИОЛДОЛ БИЙ ЮУ?

Аливаа эмнэлгийн ажиллавар, үүнд катарактын мэс засал болон үүнтэй холбоотой хиймэл болор суулгах мэс засал огт эрсдэлгүй байх нь үгүй. Гэвч хиймэл болроос үүдэлтэй таагүй нөлөө хараахан мэдэгдээгүй байна.

НАДАД ЯМАР БОЛОР СУУЛГАСНЫГ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

Мэс заслын дараа үйлчлүүлэгчид үйлдвэрлэгчийн холбоо барих хаяг бүхий үйлчлүүлэгчийн картыг өгнө. Үйлчлүүлэгчийн нэр, мэс засал хийсэн огноо, мэс засал хийсэн эмнэлгийн болон эмчийн холбоо барих хаяг зэргийг бичсэн үйлчлүүлэгчийн карт дээр үйлчлүүлэгчид суулгасан хиймэл болрын мэдээллийг дэлгэрэнгүй тусгасан байна. Хиймэл болрыг үл давтагдах серийн дугаараар танина.

ХИЙМЭЛ БОЛРЫГ ЯМАР МАТЕРИАЛААР ХИЙДЭГ ВЭ?

HumanOptics-ын хиймэл болрыг хүний биед зохицсон пластик материалаар үйлдвэрлэдэг. Энэ бол тунгалаг, биологийн хувьд зохицсон, уян бөгөөд полиакрилат (74%), давсны уусмалаас (26%) тогтсон гидрифил акрил кополимер материал байх ба хугарлын индекс 1,46, Аббе тоо 56 байна. Энэхүү материал нь мэс заслын дараа шаардагдаж болзошгүй аливаа лазер эмчилгээнд (Nd:YAG лазер) тохиромжтой.

Полиакрилатын үндсэн бүрэлдэхүүн нь хэт ягаан туяа шингээгч (<1%) бүхий 2-гидроксиэтил метакрилат (HEMA, ойр. 80%) болон метил methyl метакрилат (MMA, ойр. 20%) байна.

"У" үсгээр төгссөн загварууд нь үзэгдэх гэрлийн бүрэлдэхүүнд их хэмжээгээр байвал удаан хугацаанд нүдний торлог бүрхэвчийг гэмтээж болзошгүй хөх гэрлээс хамгаалах шүүлтүүртэй (<0,05%) байдаг.

Хиймэл болрын найрлага дахь материалаас хортой хэмжээний бодис ялгарахгүй.

МЭС ЗАСЛЫН ДАРАА БИ ЯАХ ЁСТОЙ ВЭ?

Эмчилгээний үр дүнг дээд зэргийн байлгахын тулд та нүдний эмчийн зааврыг ягштал баримталж, мэс заслын дараах товлот үзлэгт орж байх нь чухал.

Нүдний эмч өөрөөр заагаагүй бол мэс заслын дараах эхний хоёр долоо хоногт мэс засал хийлгэсэн нүдэн дээр дарах, үрэх зэрэг ямар нэгэн үйлдэл хийхээс зайлсхийх хэрэгтэй. Мөн шүршүүрт орох, угааж байх үед нүдэнд ус, саван хүргэхгүй байхыг анхаарна уу. Мөн эхэн үед биеийн хүч шаардсан үйлдэл хийх, усанд шумбах, дугуй унах, саунд орохоос зайлсхийх хэрэгтэй. Тоос, шороо ихтэй газарт байж болохгүй.

Мэс заслын дараах эхний хэдэн өдөр гялбах мэдрэмж нэмэгдэж болзошгүй тул нарны шил зүүхийг зөвлөдөг.

Шаардлагатай бол катарактын мэс заслаас хойш 4-6 долоо хоногийн дараа шинэ нүдний шил тааруулан зүүж болно. Нүд эхлээд шинэ болорт дасах шаардлагатай байдаг тул эрт шил зүүх хэрэггүй. Олон фокуст хиймэл болрын хувьд акклиматизацийн хугацаа 6 сар хүртэл байж болно. Хэрэв та нөгөө нүдэндээ удахгүй мэс засал хийлгэхээр төлөвлөсөн бол хоёр нүдний мэс заслыг хийлгэж дуустал шинэ нүдний шил тааруулж зүүхгүй зөвлөж байна. Хиймэл болрын болон бусад зүйлсийн талаар (торик= нүдний эвэрлэг бүрхүүлийн астигматизмыг засах/ олон фокуст= ойрын харааны гажиг засах) хараа зүйчдээ мэдэгдэнэ үү.

СУУЛГАСАН ХИЙМЭЛ БОЛРЫГ ХЭР УДААН ХУГАЦААНД НҮДЭНД БАЙЛГАХ ВЭ?

Эмчилгээний эсрэг заалтгүй бол ердийн нөхцөлд хиймэл болрыг үлдсэн амьдралынхаа туршид байлгана. HumanOptics хиймэл болрын ашиглах хугацаа хорин жил байдаг нь батлагдсан. Төрөлхийн болортой үйлчлүүлэгчдийн нэгэн адил ердийн нүдний эмчийн үзлэгт орж байхыг зөвлөж байна.

ХИЙМЭЛ БОЛОР MRI ОНОШИЛГООНД АЮУЛГҮЙ (НИЙЦТЭЙ) ЮУ?

Үйлчлүүлэгчид өгсөн карт дээр Соронзон резонанст дүрс оношилгооны (MRI) аюулгүй байдлын (нийцлийн) талаарх мэдээллийг дурдсан байдаг. Хиймэл болрыг нүдэнд хөдөлгөөнгүй суулгасан байдаг тул тухайн карт дээр MRI оношилгооны явцад суулгацын соронзон цацрагтай үйлчлэх талаар чухал мэдээллийг заасан байна.

HumanOptics-ын бүх хиймэл болор MRI оношилгоонд аюулгүй байдаг бөгөөд MRI оношилгооны төхөөрөмжид орсон хиймэл болорт нэмэлт хязгаарлалт тавьдаггүй. Бусад мэдээллийг www.humanoptics.com/mri хуудаснаас авна уу.

ХИЙМЭЛ БОЛОР СУУЛГАХТАЙ ХОЛБООТОЙ ЯМАР ГАЖ НӨЛӨӨ/ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРЧ ЭСВЭЛ ДОГОЛДОЛ ГЭЖ ҮЗЭЖ БОЛОХ ВЭ?

Болор суулгасны дараа дараах гаж нөлөө гарч болох бөгөөд ихэвчлэн хэсэг хугацааны дараа алга болно:

- Мэс заслын явцад болрыг суулгах зүслэгээс үүдэлтэй гаднын биет мэдрэгдэх
- Гэрэл тойрсон хүрээ ажиглагдах буюу ихэвчлэн үдшийн бүрий эсхүл харанхуйд тохиолдох (олон фокустой болорт ихэвчлэн тохиолдож болно)
- Мэс заслын дараах эхний хэдэн долоо хоногт гэрэлд мэдрэг байх



Хиймэл болор суулгахтай холбоотойгоор дараах шинж илрэх нь хүндрэлийг илтгэж болно. Хэрэв ийм шинж илэрвэл эмчдээ хандана үү:

- Хараа гэнэт эсвэл аажим аажмаар муудах/нүд бүрэлзэх
- Нүд хэт ихээр улайх
- Нүд өвдөх

Бүх урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байсан ч ховор тохиолдолд дээрх шинж тэмдэг илэрч болно. Хэрэв танд дээр дурдсан шинж илэрсэн эсвэл эдгэрэх явцад гэнэтийн асуудал гарвал нүдний эмчдээ үзүүлээрэй. Таагүй нөлөө ноцтой байвал эмч энэ талаар үйлдвэрлэгч болон эрүүл мэндийн холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой. Танай улсын эрүүл мэндийн эрх бүхий байгууллагуудыг www.humanoptics.com/patient-information хуудасны "Эрх бүхий байгууллагууд" хэсэгт дурдсан байгаа.

